

## Яллах дүгнэлтийн үндэслэл бүхий байдалд хийсэн бичил судалгаа\*

### УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ\*

- I. Гадаадын зарим улсын хууль тогтоомжид тусгагдсан байдал
  1. Бүгд Найрамдах Армени Улс
  2. Бүгд Найрамдах Болгар Улс
  3. Бүгд Найрамдах Чех Улс
  4. Гүрж Улс
  5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
  6. Бүгд Найрамдах Казахстан Улс
  7. Норвегийн Хаант Улс
  8. Бүгд Найрамдах Польш Улс
  9. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- II. Дүгнэлт

\* Энэхүү судалгаа нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн албан ёсны цахим хуудаст 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр нийтлэгдсэн болно.

\* Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Судалгааны төвийн дарга, хууль зүйн ухааны доктор Д.Янжинхорлоо (Ph.D) удирдаж, Эрүүгийн эрх зүйн секторын судлаач Б.Батбаяр, О.Инжиннаш нар 2022 оны 5 дугаар сард хийж гүйцэтгэсэн болно.



**Хураангуй:** Энэхүү судалгааны зорилго нь яллах дүгнэлтийн үндэслэл бүхий байдалд холбогдох эрх зүйн зохицуулалтыг гадаадын зарим улсын эрүүгийн процессын хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан шинжлэхэд оршино. Судалгаанд Бүгд Найрамдах Армени Улс, Бүгд Найрамдах Болгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Гүрж Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Норвегийн Хаант Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрүүгийн процессын зохицуулалтыг хамруулсан болно.

Судалгааны хүрээнд яллах дүгнэлтийн бүтэц, агуулга, нотлох баримтын хангалттай байдлын шалгуур, прокурорын хяналтын чиг үүрэг, шүүхэд шилжүүлэх ажиллагааны шаардлага, хавсралтын бүрдэл зэрэг асуудлыг задлан шинжилж, улс хоорондын ижил болон ялгаатай зохицуулалтыг тодорхойлов. Харьцуулсан шинжилгээнээс үзэхэд судалгаанд хамрагдсан улсуудыг яллах дүгнэлтийн үндэслэлийг тодорхойлох аргачлалаар нь хоёр чиг хандлагад ангилж болохоор байна. Нэгдүгээрт, яллах дүгнэлтийг үйлдэхэд "хангалттай нотлох баримт" бүрдсэн эсэхийг материаллаг шалгуур болгон тогтоодог загвар; хоёрдугаарт, яллах дүгнэлтийн үндэслэлийг прокурорын болон шүүхийн урьдчилсан хяналтын олон шатны процессын баталгаагаар давхар шалгадаг загвар байна.

Энэхүү бичил судалгаа нь яллах дүгнэлтийн үндэслэл бүхий байдлыг хангахтай холбоотой олон улсын туршлагыг нэгтгэн харуулах замаар уг институтийн процессын ач холбогдлыг тодорхойлох шинжтэй болно.

## Түлхүүр үг

Яллах дүгнэлт, яллах дүгнэлтийн үндэслэл, эрүүгийн процесс, прокурорын хяналт, нотлох баримтын хангалттай байдал, яллах дүгнэлтийн бүтэц, шүүхэд шилжүүлэх ажиллагаа

## I. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ

### 1. Бүгд Найрамдах Армени Улс

Бүгд Найрамдах Армени Улс (цаашид "БНАУ" гэх)-ын 1998 оны Эрүүгийн процессын тухай хуулийн<sup>1</sup> 38 дугаар бүлэгт "Яллах дүгнэлт бичих болон хэргийг шүүхэд шилжүүлэх" талаар зохицуулсан байдаг. Тус бүлгийн 270 дугаар зүйлд "Яллах дүгнэлт"-ийг дараах байдлаар хуульчилжээ.

270 дугаар зүйл. Яллах дүгнэлт

*Яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох, дүгнэлт хэсгүүдээс бүрдэнэ. Тэмдэглэх, тогтоох хэсгүүдэд гэмт хэргийн нөхцөл байдал, яллагдагч, хохирогчийн байдал, яллагдагчийн гэм бурууг баталж буй нотлох баримт, хохирлыг барагдуулсан талаар цуглуулсан нотлох баримтын талаар дурдана. Дүгнэлт хэсэгт яллагдагчийн мэдээлэл болон түүний үйлдсэн гэмт хэргийн зүйлчлэлийн талаар тусгаж, яллах дүгнэлт үйлдсэн огноо, газрыг дурдаж, мөрдөгч уг дүгнэлтэд гарын үсэг зурна.*

<sup>1</sup> 2016 онд нэмэлт өөрчлөлт оруулсан.



### 271 дүгээр зүйл. Яллах дүгнэлтийн хавсралт

Яллах дүгнэлтэд шүүх хуралдаанд оролцох шаардлагатай гэж мөрдөгчийн үзсэн оролцогчдын жагсаалтыг хавсаргана. Уг жагсаалтад хэргийн оролцогчдын мэдүүлэг, тэдэнтэй холбоотой бусад баримтууд хавтаст хэргийн ямар хэсэгт байгааг нэрсийнх нь ард зааж, дурдсан байна. Мөн яллагдагчийн цагдан хоригдсон хугацаа, иргэний нэхэмжлэл гаргах эрхийг хангасан эсэх тухай болон битүүмжлэгдсэн эд хөрөнгө, шүүхийн зардал, таслан сэргийлэх арга хэмжээ, эд мөрийн баримт, тэдгээрийн байршлын талаарх баримтуудыг мөрдөгч яллах дүгнэлтэд хавсаргана.

### 272 дугаар зүйл. Хэргийг прокурорт хүргүүлэх

Яллах дүгнэлтэд гарын үсэг зурсан өдөртөө багтаан мөрдөгч нь хэргийг прокурорт хянуулахаар хүргүүлнэ.

### 273 дугаар зүйл. Прокурор хэргийг хянах

Прокурор мөрдөгчийн яллах дүгнэлт үйлдэж, хүргүүлсэн хэргийг хүлээн аваад дараах зүйлсийг шалгана:

- Яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг баталсан эсэх, яллагдагчийн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж буй эсэх;
- Яллагдагчийн гэм буруугийн талаарх дүгнэлт үндэслэлтэй эсэх;
- Яллагдагчийг үйлдсэн гэж үзэж буй бүх гэмт хэргийг яллах дүгнэлтэд тусгасан эсэх;
- Гэмт хэрэгт оролцсон этгээдүүдийг бүгдийг нь яллагдагчаар татсан эсэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох, яллах дүгнэлтийг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэх;
- Таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа зөв сонгосон эсэх;
- Иргэний нэхэмжлэл, эд хөрөнгө битүүмжлэх, шүүхийн зардлын талаар авсан арга хэмжээ;
- Гэмт хэрэг гарах болсон шалтгаан, нөхцөлийг тодруулж, түүнийг арилгах арга хэмжээ авсан эсэх;
- Хэргийг бүхий л талаас нь бүрэн дүүрэн шалгасан эсэх;
- Яллах дүгнэлт нь энэ хуулийн 270, 271 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх;
- Анхан шатны мөрдөн шалгах ажиллагаа энэ хуульд заасан журмын дагуу явагдсан эсэх;
- Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах, яллах дүгнэлт дахин үйлдэхийг даалгах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;
- Хэргийг бүрэн эсхүл хэсэгчлэн хэрэгсэхгүй болгох.

*Энэ хуулийн 274 дүгээр зүйлд заасантай илт нийцэхгүй, илүү хүнд ял оногдуулах үндэслэлтэй, эсхүл ял оногдуулахгүй байх үндэслэл илэрвэл прокурор яллах дүгнэлтийг өөрчлүүлэхээр эсхүл нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр мөрдөгчид хэргийг буцаана.*



Яллах дүгнэлтийн хамт ирүүлсэн хэргийг прокурор хянаад 5 хоногийн дотор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

1. Яллах дүгнэлтийг батлах;
2. Яллах дүгнэлтэд дурдаагүй агуулгыг өөрийн дураар оруулахгүй байх, яллах дүгнэлтэд тусгасан гэмт хэрэг нь хуульд заасан гэмт хэрэгтэй зөрчилдвөл хуульд заасныг баримталж, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх байдлаар яллах дүгнэлтэд өөрчлөлт оруулах.

### 3. Бүгд Найрамдах Болгар Улс

Бүгд Найрамдах Болгар Улс (цаашид "БНБУ" гэх)-ын 2006 оны Эрүүгийн процессын хуулийн<sup>2</sup> 246 дугаар зүйлд яллах дүгнэлтийн талаар тусгасан.

246 дугаар зүйл. Яллах дүгнэлт үйлдэх

- (1) Прокурор хэргийн талаарх бодит үнэнийг шүүхээр тогтоолгох шаардлагатай хэмээн үзсэн бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх ямар нэгэн үндэслэл байхгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил илрээгүй бол яллах дүгнэлт үйлдэнэ.
- (2) Яллах дүгнэлт дэх хэргийн нөхцөл байдлын тухай хэсэг нь дараах агуулгатай байна: Яллагдагчийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн хугацаа, газар, арга хэрэгсэл; хохирогч ба түүнд учирсан хохирол; яллагдагчийн хувийн байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөлийг хэрэглэсэн байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцөл; тэдгээрийг нотолсон нотлох баримт зэрэг байна.
- (3) (2010.05.28-нд орсон өөрчлөлт) Яллах дүгнэлтийн дүгнэх хэсэг нь дараах агуулгатай байна: Яллагдагчийн хувийн байдлын талаарх мэдээлэл; эрх зүйн байдал; хэрэглэж буй Эрүүгийн хуулийн зүйл, заалт; Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлийг хэрэглэх үндэслэл байгаа эсэх, хэргийг шилжүүлэх үндэслэл бий эсэх; яллах дүгнэлт үйлдсэн огноо, газар болон яллах дүгнэлт үйлдсэн албан тушаалтныг дурдана.
- (4) Яллах дүгнэлтэд дараах зүйлсийг хавсаргана: Шүүхийн хэлэлцүүлэгт дуудагдсан хүмүүсийн жагсаалт; авагдсан цагдан хорих арга хэмжээний талаарх мэдээлэл, яллагдагчийн цагдан хоригдсон хугацаа, эд мөрийн баримт болон бичмэл нотлох баримтууд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, авагдсан таслан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээлэл; энэ хуулийн 63 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан хүүхэд хамгааллын байрны талаарх мэдээлэл зэрэг байна.

### 3. Бүгд Найрамдах Чех Улс

Бүгд Найрамдах Чех Улс (цаашид "БНЧУ" гэх)-ын 1961 оны Эрүүгийн процессын хуульд<sup>3</sup> яллах дүгнэлтийг дараах байдлаар хуульчилсан.

<sup>2</sup> 2011 онд нэмэлт өөрчлөлт орсон.

<sup>3</sup> 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон.

176 дугаар зүйл. Яллах дүгнэлт

- (1) Мөрдөн шалгах ажиллагааны үр дүн яллагдагчийг шүүхэд шилжүүлэхэд хангалттай байвал улсын яллагч яллах дүгнэлт үйлдэн хавсралт болон бусад баримтыг хавсаргаж, бэлдэнэ. Яллагдагч, хохирогчийн оршин суугаа газар, эсхүл ажлын хаяг нь мэдэгдэж байвал тэдэнд, хэрэв яллагдагч нь өөрөө өмгөөлөгч бол яллах дүгнэлт үйлдэгдсэн талаарх мэдээллийг Ерөнхийлөгчийн тамгын газар болон Хууль зүйн яаманд тус тус мэдэгдэнэ.
- (2) Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болсон гэм буруутай үйлдэлд нь тусад нь яллах дүгнэлт үйлдэж болно. (160 дугаар зүйл). Прокурор нь мөрдөгчийн зүйлчилсэн гэмт хэргээс өөр гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл, эс үйлдэхүйг яллагдагч хийсэн гэж үзвэл яллагдагч болон түүний өмгөөлөгчид мэдэгдэж, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаанд буцаах, тэдний хүсэлтийн үндэслэл нь прокурорын үзэж буй зүйлчлэлийн өөрчлөлттэй нийцэж буй эсэхийг тодруулна.

177 дугаар зүйл. Яллах дүгнэлтийн агуулга

Яллах дүгнэлт нь дараах агуулгатай байна:

- a) Яллах дүгнэлт үйлдсэн прокурорын албан тушаал, яллах дүгнэлт үйлдсэн огноо,
- b) Яллагдагчийн овог, нэр, төрсөн газар, огноо, эрхэлсэн ажил, оршин суух хаяг, бусад хувийн байдалтай холбоотой шаардлагатай мэдээлэл; яллагдагч нь зэвсэгт хүчинд харьяалагддаг бол цол, харьяа байгууллагын талаар дурдана,
- c) Тогтоох хэсэгт яллагдагчийн гэмт үйлдэл, эс үйлдэхүй, гэмт хэрэг үйлдсэн газар, хугацаа, арга, бусад гэмт хэргээс ялгах болон эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэлтэй болохыг дэмжсэн бусад үйл баримтуудыг тусгана. Мөн ялтны Эрүүгийн хуулийн аль зүйл хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн болохыг болон тус гэмт хэргийн шинжийг дурдаж, оногдуулах ялын хэмжээг төлөвлөж заасан байна.
- d) Яллах дүгнэлтэд ийнхүү дүгнэлт гаргах үндэслэл болсон нотлох баримтын жагсаалт, холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалтууд, тэдгээрийг хэрэглэж гаргасан хууль зүйн дүгнэлт зэргийг тусгана.

#### 4. Гүрж Улс

Гүрж улсын 2009 оны<sup>4</sup> Эрүүгийн процессын хуульд яллах дүгнэлттэй холбоотой дараах зохицуулалтуудыг тусгасан.

169 дүгээр зүйл. Яллах дүгнэлт

1. Яллах дүгнэлт үйлдэх үндэслэл нь гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүйг хангалттай нотолж буй нотлох баримтуудаас бүрдэх юм.
2. Хэргийг шүүхэд шилжүүлэх хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл прокурор гэмт этгээдийг яллах дүгнэлт үйлдэнэ.

<sup>4</sup> 2021 онд нэмэлт өөрчлөлт орсон.



3. Яллах дүгнэлт үйлдсэний дараа прокурор шүүхэд шилжүүлэх хугацаа, байршлыг тогтоох бөгөөд яллах дүгнэлт үйлдсэнээс хойш 24 цагт багтаан шүүхэд хүргүүлнэ.
4. Яллах дүгнэлтэд дараах зүйлсийг тусгана:
  - a. Яллагдагчийн нэр, эцгийн нэр, ургийн овог, төрсөн он, сар, өдөр, регистрийн дугаар;
  - b. Яллах дүгнэлт нь бүтцийн хувьд гэм буруутай үйлдэл, гэмт хэрэг үйлдэгдсэн газар, хугацаа, арга, хэрэгсэл, үр дагавар;
  - c. Яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүйг нотлох мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд цуглуулсан нотлох баримт;
  - d. Тухайн гэмт хэргийг тодорхойлсон Гүржийн Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт.
5. Яллах дүгнэлт нь яллагдагчийг яллаж буй тогтоох хэсгийг заавал агуулна.

Прокурор, эсхүл түүний даалгавраар мөрдөгч нь яллагдагч болон түүний өмгөөлөгчид (хэрэв бий бол) яллах дүгнэлтийн талаар танилцуулж, гарын үсэг зурж баталгаажуулан яллах дүгнэлтийг хуулбарлана. Яллах дүгнэлтийн хуулбарын хамт яллагдагчид эрх үүрэг тайлбарласан баримтыг яллагдагч болон түүний өмгөөлөгчид хүргүүлнэ. Хэрэв яллагдагч болон түүний өмгөөлөгч нь яллах дүгнэлт болон түүний хуулбартай танилцсан атлаа гарын үсэг зурахаас татгалзвал үндэслэлийг нь яллах дүгнэлтэд тусгана.

6. Яллагдагч нь мөрдөгчийн дуудсан цагт хүрэлцэн ирэхээс зайлсхийвэл түүнд болон түүний төрөл саданд түүнийг өмгөөлөх өмгөөлөгч авах боломжит хугацаа олгоно. Боломжит хугацаанд яллагдагч өмгөөлөгч авч чадаагүй бол түүнийг өмгөөлүүлэхээр улсын өмгөөлөгч томилно. Хэргийг шүүхэд шилжүүлэхийн тулд прокурор, эсхүл түүний даалгавраар мөрдөгч нь өмгөөлөгчид яллах дүгнэлтийг танилцуулна. Уг яллах дүгнэлт нь шүүхийн өмнө танилцуулах яллах дүгнэлт байна. Яллагдагчийн өмгөөлөгч нь яллах дүгнэлттэй танилцсан болохоо баталж, яллах дүгнэлт танилцуулсан баримтад гарын үсэг зурна.
7. Гүржийн Үндсэн хуулийн шүүхийн гишүүнийг яллахын тулд тус шүүхийн бүх гишүүдийн хурлыг хуралдуулж гишүүдээс зөвшөөрөл авах ёстой. Улсын ерөнхий байцаагч буюу Ерөнхий аудиторыг яллахын тулд Гүржийн парламентаас зөвшөөрөл авах ёстой. Гүржийн дээд шүүхийн болон бусад шүүхийн шүүгчийг яллахын тулд Гүржийн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зөвшөөрөл авах ёстой.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болохоос өмнө 9 сараас ихгүй хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэрэгт яллагдагчаар татагдаагүй бол яллагдагчийг анх удаа гэмт хэрэг үйлдсэнд тооцож шийдвэрлэж болно. Дээр дурдсан хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэрэгт яллагдагчаар татахад өмнөх яллагдагчаар татагдсан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зогсох бөгөөд шинэ хэрэгт яллагдагчаар татагдсан өдрөөс үргэлжлүүлэн тоолно. Тус хөөн хэлэлцэх хугацаа нь дуусвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болно. Энэ хэсэгт



заасан үндэслэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол ижил үндэслэлээр яллагдагчийг дахин яллахыг хориглоно.

8. Яллах дүгнэлтийг гардан авснаас хойш 10 хоногийн дотор, энэ хуульд заасан тохиолдолд дээд шатны прокурорт, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулсан харьяа дүүргийн шүүхэд гомдол гаргаж болох ба гомдлыг хүлээн авсан дээд шатны прокурор эсхүл харьяалах дүүргийн шүүх нь 3 хоногийн дотор хянана. Шүүх гомдлыг хуралдахгүйгээр хянаж болно. Яллагдагчийг буруутгасан, мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримт нь нотлох баримтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдвол гомдлыг хангаж шийднэ. Энэ хэсэгт заасан бол гомдол шийдсэн шүүхийн тогтоолын талаар энэ хуулийн 207 дугаар зүйлд заасны дагуу харьяалах давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

## 5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд найрамдах Герман Улс (цаашид "ХБНГУ" гэх)-ын 1950 оны<sup>5</sup> Эрүүгийн процессын хуульд яллах дүгнэлтийг дараах байдлаар хуульчилсан байдаг.

200 дугаар зүйл. Яллах дүгнэлтийн агуулга

- (1) Яллах дүгнэлтэд яллагдагчийн талаар болон түүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн хугацаа, газар, гэмт хэргийн бүрэлдэхүүн, уг гэмт хэргийн Эрүүгийн хуульд туссан байдал буюу зүйл, хэсэг, заалтыг тусгана. Мөн нотлох баримт, харьяалах шүүх, яллагдагчийн өмгөөлөгчийн талаар дурдана. Гэрчийг тодорхойлсон бол түүний байгаа, эсхүл оршин суудаг газрыг тодорхойлсон байх шаардлагатай бөгөөд дэлгэрэнгүй хаягийг тусгах шаардлагагүй. 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дугаар, 2 дахь хэсгийн 1 дүгээр өгүүлбэрт заасан тохиолдолд гэрчийн нэрийг нь дурдах л хангалттай. Хувийн мэдээлэл нь бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн нууцлагдсан гэрчийн мэдүүлгийн хувьд мэдүүлэгт дурдсан үйл баримтыг заана; гэрчийн байгаа газар болон оршин байгаа газар нь нууцлагдсан бол ижил журам үйлчилнэ.
- (2) Яллах дүгнэлтэд мөрдөн шалгах ажиллагааны холбогдох үр дүнг тусгана. Хэрэв тус үр дүнтэй холбоотой асуудлыг шүүхээр хэлэлцэх нь зүйтэй гэж үзвэл тусгахгүй байж болно.

201 дүгээр зүйл. Яллах дүгнэлтийг танилцуулах

- (1) Даргалагч шүүгч яллагдагчид яллах дүгнэлтийг танилцуулж, түүнд тогтоосон хугацааны дотор буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхээс өмнө бие даасан нотлох баримт гаргуулах хүсэлт гаргах эсэхийг нь, эсхүл ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхийг эсэргүүцэх үндэслэл бүхий хүсэлт бий эсэхийг тодруулна. Мөн яллах дүгнэлтийг хувийн туслах прокурор болон хувийн туслах прокурорын хувиар хүсэлт гаргасан этгээдэд танилцуулна. 145а-ийн 1 болон 3 дахь хэсгийг зохих ёсоор баримтална.

<sup>5</sup> 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон.



Шүүх гаргасан хүсэлт болон эсэргүүцлийг шийдвэрлэнэ. Уг шийдвэр нь эцсийнх байна.

## 6. Бүгд Найрамдах Казахстан Улс

Бүгд Найрамдах Казахстан Улс (цаашид "БНКУ" гэх)-ын 2014 оны<sup>6</sup> Эрүүгийн процессын хуульд яллах дүгнэлтийг дараах байдлаар хуульчилсан байдаг.

38 дугаар бүлэг. Яллах дүгнэлтийн төсөл бэлдэх, эрүүгийн хэргийг прокурорт шилжүүлэх

1. Шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан албан тушаалтан хэргийг хэргийн оролцогчдод танилцуулж, тэдгээрийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн бол яллах дүгнэлт үйлдэнэ.
2. Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй яллагдагчийн хувьд он цагийн дарааллаар яллах дүгнэлтэд тусгана.

299 дүгээр зүйл. Яллах дүгнэлтийн агуулга

1. Яллах дүгнэлт нь удиртгал, тэмдэглэх, тогтоох хэсэгтэй байна.
2. Удиртгал хэсэгт дараах зүйлсийг тусгана:
  - 1) Яллах дүгнэлт үйлдсэн газар, хугацаа;
  - 2) Яллах дүгнэлт үйлдсэн хүний овог, нэр, албан тушаал;
  - 3) Яллагдагчийн овог, нэр, ургийн овог, төрсөн газар, жил, сар, өдөр.
2. Тэмдэглэх хэсэгт дараах зүйлсийг тусгана:
  - 1) Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, хугацаа, газар, арга, сэдэл, үр дагавар болон бусад нөхцөл байдлын талаар;
  - 2) Хохирогчийн талаар мэдээлэл, түүнд учирсан шууд болон шууд бус хохирол;
  - 3) БНКУ-ын Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлд зааснаар хураан авах боломжтой эд хөрөнгийн мэдээлэл;
  - 3-1) БНКУ-ын Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлд зааснаар хураан авах боломжтой эд хөрөнгө байгааг баталсан нотлох баримтын жагсаалт;
  - 4) Яллагдагчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлууд;
  - 5) Яллагдагчийн талаарх мэдээлэл (иргэншил, гэрлэлтийн байдал, эрхэлсэн ажил, боловсрол, оршин суугаа газар, гэмт хэрэг үйлдсэн эсэх тухай лавлагаа) болон яллагдагчийг тодорхойлох бусад мэдээлэл, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ;
  - 6) Яллах дүгнэлтийн үндэслэл болсон нөхцөл байдлуудыг дэмжих нотлох баримтын жагсаалт;
  - 7) Согтууруулах ундаа, мансууруулах бодис бусад донтолтын эсрэг эмчилгээнд тавигдах урьдчилсан нөхцөлүүдийн талаарх мэдээлэл.

<sup>6</sup> 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон.



4. Яллах дүгнэлтийн тогтоох хэсэгт яллагдагчийн овог, нэр, ургийн овог, Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг тусгаж, эрүүгийн хэргийг прокурорт хүргүүлнэ. Прокурор яллах дүгнэлтийг батлах эсэхийг шийдвэрлэж, баталсан тохиолдолд шүүхэд шилжүүлнэ.
5. Яллах дүгнэлт үйлдсэн этгээдийг дурдана.
6. Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйлд заасан гэмт хэргийг яллагдагч үйлдсэн тохиолдолд тус бүрийг нь яллах дүгнэлтэд тодорхой бичнэ. Хэрэв хэд хэдэн яллагдагч гэмт хэрэг үйлдсэн бол тус бүрийг нь яллах дүгнэлтэд тусгана.
7. Яллах дүгнэлтэд шүүх хуралдаанд оролцох этгээдүүдийн жагсаалтыг хавсаргана. Уг жагсаалтад оролцогчдын овог, нэр, ургийн овог, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь эрх зүйн байдал, оршин суугаа хаяг, тэдний өгсөн мэдүүлэг болон тэдгээрийг агуулсан хавтаст хэргийн дугаар.

Жагсаалт нь 2 хэсгээс бүрдэнэ: Эхний хэсэгт яллагдагч болон яллагдагчийн өмгөөлөгчдийн жагсаалт буюу цагаатгах талын оролцогчдын жагсаалт, шүүхийн өмнөх шатны ажиллагааг гардан гүйцэтгэсэн албан тушаалтнуудын жагсаалт буюу яллах талын оролцогчдын жагсаалт. Уг жагсаалтыг дугтуйнд хийж лацдан хавтаст хэрэгт хавсаргана.

Мөн яллах дүгнэлтэд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хугацаа, таслан сэргийлэх арга хэмжээ, цагдан хоригдсон хугацаа, эд мөрийн баримт болон тэдгээрийг хадгалж буй байршил, авагдсан таслан сэргийлэх арга хэмжээнүүд, иргэний нэхэмжлэл, шүүхийн шийдвэрийг биелүүлсэн байдал, шүүхийн зардал болон яллагдагч хохирогчид учруулсан хохирлоо барагдуулсан байдал.

300 дугаар зүйл. Яллах дүгнэлт болон хэргийг прокурорт хүргүүлэх

1. Яллах дүгнэлтийн төслийг бэлтгэсний дараа мөрдөн шалгах ажиллагааг явуулсан албан тушаалтан тус төслийг хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.
2. Яллагдагч цагдан хоригдсон бол хэрэгт түүний биеийн байцаалтыг агуулсан баримт бичгийг хавсаргана. Бусад тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан албан тушаалтны үйлдсэн баталгаа бүхий баримт бичгийг хавсаргана.
3. Яллагдагч нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн бөгөөд түүнд иргэний үнэмлэх байхгүй байх онцгой тохиолдолд өөр баримт бичгийг орлуулан хавсаргаж болно. Энэ зүйлд заасан биеийн байцаалтыг тодорхойлох баримт бичгүүд нь дараах байна:
  - 1) БНКУ-аас олгосон иргэний паспорт;
  - 2) БНКУ-ын иргэний үнэмлэх;
  - 3) БНКУ-д оршин суух зөвшөөрөл;
  - 4) Харьяалалгүй болохыг баталсан гэрчилгээ;
  - 5) БНКУ-ын дипломат паспорт;
  - 6) БНКУ-ын үйлчилгээний паспорт;



- 7) Дүрвэгчийн гэрчилгээ;
- 8) Далайчны үнэмлэх;
- 9) Гадаад паспорт;
- 10) Жолооны үнэмлэх;
- 11) Буцаах гэрчилгээ;
- 12) Иргэншлийг гэрчлэх баримт бичиг авах насанд хүрээгүй хүний төрсний гэрчилгээ;
- 13) Төрсний бүртгэл;
- 14) Цэргийн үүрэгтний үнэмлэх.

39 дүгээр бүлэг. Яллах дүгнэлтийн хамт ирүүлсэн эрүүгийн хэрэгт прокурорын гаргах шийдвэр

301 дүгээр зүйл. Яллах дүгнэлтийн хамт ирүүлсэн эрүүгийн хэргийг прокурор хянахдаа шалгах асуудлууд

Яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргээс прокурор дараах зүйлсийг шалгана:

- 1) Яллагдагчийн гаргасан үйлдэл, эс үйлдэхүй нь эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй мөн эсэх;
- 2) Гэмт хэргийг үйлдэгдэхэд хүргэсэн нөхцөл байдлууд;
- 3) Яллагдагчийн үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж байгаа эсэх;
- 4) Яллагдагчийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг нотлох баримт бий эсэх ;
- 5) Гэмт үйлдлийнх нь улмаас тухайн этгээдийг яллагдагчаар татсан эсэх;
- 6) Нотлох баримтаар гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож буй бүх хүмүүсийг яллагдагчаар татсан эсэх;
- 7) Таслан сэргийлэх арга хэмжээг зөв сонгон хэрэглэсэн эсэх болон түүнийг өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэл;
- 8) Иргэний нэхэмжлэл дэх шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан эсэх (эд хөрөнгийг хураах боломжтой эсэх);
- 8-1) Яллагдагч нь БНКУ-ын Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлд зааснаар хураах боломжтой гэмт хэрэгт холбогдсон эсэх, эд хөрөнгийг хураах үндэслэл бүрдсэн эсэх
- 9) Мөрдөн шалгах ажиллагааны явцад эрүүгийн процессын хуулийг ноцтой зөрчсөн эсэх;
- 10) Шүүхийн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын тооцоог мөрдөн шалгах байгууллага тодорхойлсон эсэх;
- 11) Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэл бий эсэх.



302 дугаар зүйл. Яллах дүгнэлтийн хамт ирүүлсэн эрүүгийн хэрэгт прокурорын гаргах шийдвэр

Хэргийг хянаад прокурор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1) Яллах дүгнэлтийг батлах;
  - 2) Яллах дүгнэлтийг шинээр үйлдэх;
  - 3) нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр мөрдөгчид хэргийг буцаах;
  - 4) Энэ хуулийн 35, 36 дугаар зүйлүүдэд заасан үндэслэлээр хэргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хэрэгсэхгүй болгох;
  - 5) Яллагдагч болон түүний өмгөөлөгчдийн хүсэлт, эсхүл прокурор өөрийн саналаар хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх;
  - 6) Шүүх хуралдаанд оролцуулах этгээдүүдийн жагсаалтад шаардлагатай гэж үзсэн этгээдийг нэмэх, эсхүл шаардлагагүй гэж үзсэн этгээдийг хасах. Энэ заалт нь цагаатгах талын гэрчүүдэд хамаарахгүй.
1. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйлсийг прокурор дараах хугацаанд хийж гүйцэтгэнэ:
- 1) Шуурхай журмаар мөрдөн шалгах ажиллагаа явагдсан хэрэгт 3 хоног;
  - 2) Ердийн журмаар мөрдөн шалгах ажиллагаа явагдсан хэрэгт 10 хоног.

## 7. Норвегийн Хаант Улс

Норвегийн Хаант Улс (цаашид "НХУ" гэх)-ын 1981 оны<sup>7</sup> Эрүүгийн процессын хуульд яллах дүгнэлтийг дараах байдлаар хуульчилжээ.

249 дүгээр зүйл. Хэрэгт нотлох баримт хангалттай цуглармагц яллах дүгнэлт үйлдэх

Гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй этгээд яллагдагчаар татагдсанаас хойш 6 долоон хоногийн дотор яллах дүгнэлт үйлдэнэ. Шаардлагатай онцгой тохиолдолд уг хугацааг сунгаж болно.

250 дугаар зүйл. Яллах дүгнэлт үйлдэх үндэслэл хангалттай бүрдсэн ч яллагдагчийн байгаа газар тодорхойгүй, эсхүл гадаад улсад байгаа бол хэрэг хянан шийдвэрлэх хугацаа зогсоно. Нотлох баримт устах, гэмтэх аюултай бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа зогссон эсэхийг үл харгалзан нотлох баримтыг цуглуулна.

251 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал яллагдагчийн хувьд бий болсон гэж үзэх үндэслэл байвал, мөн яллагдагч 84 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хуралдаанд оролцохоос татгалзсан, мөн Эрүүгийн хуулийн 39 а-д заасны дагуу албадан ирүүлэх, эсхүл хорих, мөн хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу сэтгэцийн албадан эмчилгээнд хамруулна.

<sup>7</sup> 2013 онд нэмэлт өөрчлөлт орсон.



Яллах дүгнэлт үйлдэхэд түр зуурын саад үүссэн гэх үндэслэл илэрвэл энэ үйл ажиллагааг түр зогсоож болно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түр зогссон үед 250 дугаар зүйл хэрэглэгдэх бөгөөд яллах дүгнэлт үйлдэх ажиллагаа мөн зогсоно.

252 дугаар зүйл. Яллах дүгнэлтэд огноог бичиж, гарын үсгээр баталгаажуулах бөгөөд дараах агуулгыг тусгана:

- 1) Харьяалах шүүхийн нэр,
- 2) Яллагдагчийн нэр, оршин суугаа газрын хаяг,
- 3) Хэрэгт чухал ач холбогдолтой гэж үзвэл хэрэглэгдэх эрүүгийн хуулийн заалтын талаарх тайлбар,
- 4) Яллах дүгнэлттэй холбоотой асуудлууд болон хэргийн газар, үйлдэгдсэн цаг хугацааны талаар товч бөгөөд тодорхой мэдээлэл.

Яллах үйл ажиллагаа нь нийтэд нээлттэй эсэхийг яллах дүгнэлтэд заана.

Ял шийтгэлээс гадна нэхэмжлэл байвал тэр талаар тусгана. Хэрэв яллах эрх бүхий албан тушаалтан 427 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэл гаргасан бол түүнийхээ хэмжээг заана.

253 дугаар зүйл. Шүүх хуралдаан болохоос өмнө яллах эрх бүхий албан тушаалтан яллах дүгнэлтийг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл гэмт хэргийн шинэ зүйл анги нэмж тусгах, эсхүл зүйлчлэлийг сольж болно. Яллах дүгнэлтэд оруулах бусад нэмэлт, өөрчлөлтөд энэ журам нэгэн адил үйлчилнэ.

254 дүгээр зүйл. Шүүх хуралдааны үед прокурор яллах дүгнэлтээс хэсэгчлэн эсхүл бүхэлд нь татгалзаж болно. Хэрэв яллах дүгнэлт нь Улсын ерөнхий прокурор эсхүл хаантай холбоотой хэргийн тухай байвал прокурор яллах дүгнэлтээс татгалзах талаар Улсын ерөнхий прокуророос зөвшөөрөл авна.

Яллагдагчийн хэргээ илчилсэн мэдүүлэг нь бусад нотлох баримтаар давхар нотлогдож байвал шүүхийн зөвшөөрлөөр яллах эрх бүхий албан тушаалтан яллах дүгнэлтийг өөрчилж болно. Яллах дүгнэлтэд оруулах бусад нэмэлт, өөрчлөлтийг яллах эрх бүхий этгээд үйлдэнэ. Шүүхээс яллагдагчид завсарлага өгөх нь цагаатгах талд ашигтай гэж үзвэл түүнд завсарлага өгнө.

## 8. Бүгд Найрамдах Польш Улс

Бүгд Найрамдах Польш Улс (цаашид "БНПУ" гэх)-ын 1997 оны<sup>8</sup> Эрүүгийн процессын хуульд дараах байдлаар хуульчилжээ.

331 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа, эсхүл хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэргийн яллах дүгнэлтийг хүлээн авсан бол улсын ялагч шүүхэд хэргийг шилжүүлэх, эсхүл нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шийдвэр гаргана.

<sup>8</sup> 2003 онд нэмэлт өөрчлөлт орсон.



2 дахь хэсэг. Хэрэв яллагдагч цагдан хоригдож байсан бол 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээнүүдийн хугацаа 7 хоног байна.

332 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Яллах дүгнэлт дараах агуулгатай байна:

- 1) Яллагдагчийн овог, нэр, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эсэх талаар болон бусад мэдээлэл,
- 2) Яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн арга, хугацаа, газар, нөхцөл байдал, учруулсан хохирол болон хохирлын хэмжээ,
- 3) Эрүүгийн хуулийн 64 дүгээр зүйлд заасан нөхцөлүүдийн дагуу гэмт үйлдлийг тодорхойлох,
- 4) Гэмт үйлдлийн хамаарах гэмт хэргийн ангилал,
- 5) Тухайн хэргийн харьяалах шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл (ердийн, хялбаршуулсан)
- 6) Шийдвэрийн талаарх үндэслэл.

2 дахь хэсэг. Шийдвэрийн үндэслэлд яллах үндэслэл болсон бүхий л нотлох баримт, үйл баримтуудыг дурдана. Шаардлагатай бол яллаж буй хууль зүйн үндэслэл болон цагаатгах талын нөхцөл байдлуудыг ч мөн дурдана.

333 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Яллах дүгнэлт нь дараах агуулгатай байна:

- 1) Прокуророос дуудан ирүүлэх шаардлагатай гэж үзсэн хүмүүсийн нэрсийн жагсаалт,
- 2) Анхан шатны шүүх хуралдаан дээр прокуророос цуглуулах шаардлагатай гэж үзсэн бусад нотлох баримтын жагсаалт,

2 дахь хэсэг. Хилийн чанадад байгаа гэрчийн өгсөн мэдүүлгийг шүүх хуралдаан дээр уншиж сонсгох боломжтой гэж үзвэл прокурор тэднийг дуудан ирүүлэхээс татгалзах хүсэлтийг шүүхэд гаргаж болно; Тухайн үйл баримтууд нь гэрчүүдийг шүүх хуралдаан дээр шууд шалгах чухал ач холбогдолтой биш бол яллагдагчийн тайлбараар няцаагдаагүй үйл баримтыг баталгаажуулах зорилгоор дуудагдсан гэрчид мөн энэ зохицуулалт үйлчилнэ; Энэ заалт 182 дугаар зүйлд заасан жагсаалтад орсон хүмүүст хамаарахгүй.

3 дахь хэсэг. Шүүхэд мэдээлэл өгөх зорилгоор 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтад заасан хүмүүсийн хаяг болон гэмтсэн хүмүүсийн хаягийг яллах дүгнэлтэд хавсаргана.

4 дэх хэсэг. Улсын ялагч нь Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлд заасан аж ахуйн нэгжид аливаа гэмт хэргийн улмаас олсон аливаа материаллаг баялгийг төрийн санд буцаан суулгах хүсэлтийг яллах дүгнэлтэд хавсаргаж болох бөгөөд шүүх хуралдааны товыг аж ахуйн нэгжид мэдэгдэнэ. Уг хүсэлтэд үндэслэлийг сайтар тусгана.

334 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримтууд болон хэрэгт хавсаргасан бусад баримтуудын хамт яллах дүгнэлтийг яллагдагчдын тоогоор хуулбарлаж шүүхэд хүргүүлнэ.



2 дахь хэсэг. Яллах дүгнэлтийг үйлдэж, шүүхэд шилжүүлсэн болохыг улсын яллагч нь яллагдагч, хохирогч, гэмт хэргийн талаар мэдээлсэн хувь хүн, байгууллагад мэдэгдэнэ. Хохирогчид энэ талаар мэдэгдэхдээ улсын яллагч нь түүнд мөн хохирлоо нэхэмжлэх эрх бий болохыг мэдэгдэж, шаардлагатай бол туслах прокурорын үүрэг гүйцэтгэх талаар хүсэлт гаргах эрхтэй тухайд нь уламжилна. Улсын яллагч яллагдагчийн зөвшөөрснөөр яллах дүгнэлтэд өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт оногдуулахаар төлөвлөсөн ялын санал нь 5 жилээс ихгүй хорих ялтай бол яллах дүгнэлтэд хавсарган шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр хөнгөрүүлэх нөхцөл ашиглан ял оногдуулах, эсхүл гэмт хэрэг үйлдсэн болох нь эргэлзээгүй тодорхой, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүйгээр мөрдөн шалгах ажиллагаагаар хангалттай үр дүнд хүрэх боломжтой байвал яллахаас татгалзах, болзол тавьж ял хойшлуулах, эсхүл Эрүүгийн хуулийн 39 дүгээр зүйлийн 1-3, 5-8 дахь хэсгүүдэд зааснаар ямар ял оногдуулахыг шийднэ.

## 9. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид "БНХАУ" гэх)-д прокурорын яллах дүгнэлт, хяналтын ажилтай холбоотойгоор дараах хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж байна. БНХАУ-ын Прокурорын тухай хуулийн долоодугаар зүйл. Прокурорын мэргэжлийн үүргийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- ардын прокурорын газрын хүлээн авсан эрүүгийн хэргийг хуульд заасны дагуу хянах;
- эрүүгийн хэрэгт баривчлах, яллахыг хянах, улсыг төлөөлж яллах;
- нийтийн эрх ашгийг дэлгэрүүлэн ажиллах;
- эрүү, иргэн, захиргааны хэрэгт хяналт тавьж ажиллах;
- хуульд заасан бусад мэргэжлийн үүрэг.<sup>9</sup>

### АРДЫН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ЗАРГАЛДАХ ДҮРЭМ

330 дугаар зүйл. Ардын прокурорын газарт хянан шалгуулахаар шилжүүлсэн хэрэгт дараах зүйлсийг заавал нягтлан тогтооно.<sup>10</sup> Үүнд:

- сэжигтний хувийн байдал тодорхой эсэх, овог нэр, хүйс, улсын харьяалал, төрсөн он, сар, өдөр, мэргэжил болон байгууллага зэрэг; байгууллагатай холбоотой нөхцөл байдал тодорхой эсэх;
- гэмт хэргийн бодит байдал, нөхцөл байдал тодорхой эсэх, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, газар, арга, хор аюул нь илэрхий тодорхой эсэх;
- гэмт хэргийн объектив талын шинж болон яллах санал оновчтой эсэх, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал оновчтой эсэх;
- сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээсэн эсэх;
- хэргийн бодит байдлыг батлах эд мөрийн баримт хавтаст хэрэгтэй

<sup>9</sup> БНХАУ-ын прокурорын хууль, [https://www.spp.gov.cn/zdgz/201904/t20190423\\_415970.shtml](https://www.spp.gov.cn/zdgz/201904/t20190423_415970.shtml) (Сүүлд үзсэн: 2022.03.02).

<sup>10</sup> БНХАУ-ын прокурорын байгууллагын эрүүгийн хэрэгт заргалдах дүрэм, [https://www.spp.gov.cn/spp/xwfbh/wsfbh/201912/t20191230\\_451490.shtml#4](https://www.spp.gov.cn/spp/xwfbh/wsfbh/201912/t20191230_451490.shtml#4) (Сүүлд үзсэн: 2022.03.02).



шилжиж ирсэн эсэх; хууль бусаар олсон орлогыг батлах эд мөрийн баримтыг хэрэгтэй хамт шилжүүлсэн эсэх; хавтаст хэрэгтэй хамт шилжүүлэхэд зохимжгүй нотлох баримтын нарийвчилсан жагсаалт<sup>11</sup>, хуулбар, зураг эсхүл бусад нотлох баримт хэрэгтэй хамт шилжиж ирсэн эсэх;

- нотлох баримт баттай, хангалттай, хуульд зааснаар цуглуулсан эсэх, хууль бус нотлох баримтыг хасах нөхцөл байгаа эсэх;
- мөрдөн шалгах арга хэрэгслийг хуульд заасан арга хэлбэрээр явуулсан эсэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан болон яллах бичиг баримт бүрэн гүйцэд эсэх;
- гэмт үйлдэл дутуу үлдээсэн болон хөөн хэлэлцэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой бусад этгээд байгаа эсэх;
- заавал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа эсэх;
- авсан албадлагын арга хэмжээ нь тохирсон эсэх, баривчилсан сэжигтнийг үргэлжлүүлэн хорих шаардлагатай эсэх;
- мөрдөн шалгах ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- хэрэгт холбогдуулан битүүмжилсэн, барьцаалсан, царцаасан эд хөрөнгийг сайтар хадгалан хамгаалсан эсэх, нарийвчилсан жагсаалт бүрэн эсэх; хохирогчид хууль ёсны хөрөнгийг буцаан олгох болон хориотой бараа, эсхүл урт хугацаанд хадгалах боломжгүй түргэн муудах эд зүйлийг зохистой шийдвэрлэсэн эсэх, шилжүүлсэн баталгаа нь бүрэн гүйцэд эсэх.

БНХАУ-ын эрүүгийн процессын хуульд улсын ялагчид хамаарах дараах зохицуулалтууд байна. Үүнд:

53 дугаар зүйл. **【Нотлох баримт ашиглах зарчим】**Цагдаагийн байгууллагын баривчлуулах тогтоол, Ардын прокурорын газрын яллах дүгнэлт, Ардын шүүхийн шийдвэр нь бодит үнэнд нийцсэн шударга байх ёстой. Санаатайгаар бодит үнэнийг нуун далдалсан бол хариуцлага хүлээх ёстой.

186 дугаар зүйл. **【Яллах дүгнэлтийг хянах】**Ардын шүүх нь яллах дүгнэлтийг хянасны дараа яллах дүгнэлтэд гэм буруутай нь илэрхий тодорхой байвал, шүүх хурлаар хэлэлцүүлнэ.

187 дугаар зүйл. **【Шүүхээр хэлэлцүүлэхийн өмнөх бэлтгэл】**Ардын шүүхээр хэлэлцүүлэхээр шийдвэр гарсны дараа, шүүх бүрэлдэхүүнийг тогтоож, яллах дүгнэлтийн хуулбарыг шүүх хуралдаанаас 10 хоногийн өмнө шүүгдэгч болон өмгөөлөгчид хүргэнэ.

191 дүгээр зүйл. **【Шүүхийн хэлэлцүүлэг】**Улсын ялагч шүүх танхимд яллах дүгнэлтийг уншиж сонгосны дараа, шүүгдэгч, хохирогч яллах дүгнэлтэд дурдсан гэмт хэргийн талаар тайлбарлах, улсын ялагч шүүгдэгчээс мэдүүлэг авч болно.

<sup>11</sup> «Ардын дээд шүүхийн тайлбар» 291 дүгээр зүйл. Хавтаст хэрэгтэй хамт шилжүүлэх боломжгүй нотлох баримтад зөвөөрлөхөд хүндрэлтэй, овор хэмжээ ихтэй, амархан муудаж шинж чанараа алддаг эд зүйл, галт зэвсэг, сум, дэлбэрэх аюултай болон шатамхай бодис зэрэг биет нотлох баримт орно.



49 дүгээр зүйл. Ардын шүүх хуулийн туслалцаа үзүүлэх байгууллагаас өмгөөлөгч томилохоор мэдэгдсэн бол хуулийн туслалцаа үзүүлэх мэдэгдэл бичиг, яллах дүгнэлтийн хуулбар эсхүл шүүхийн шийдвэрийг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад хүргүүлнэ; шүүхээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бол хялбаршуулсан эсхүл түргэвчилсэн журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд, шүүх хуралдаан эхлэхээс 10 хоногийн өмнө дээр дурдсан материалыг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад хүргүүлнэ.

128 дугаар зүйл. Ардын шүүх шүүгдэгч болон түүний өмгөөлөгчид яллах дүгнэлтийн хуулбарыг хүргүүлэх үед хууль бус нотлох баримтыг хасуулах хүсэлтийг гаргах бөгөөд шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргах ёстой. Гэвч шүүхээр хэлэлцүүлэх үед хэрэгт холбоотой шалтгаан нөхцөл эсхүл материал илэрсэн тохиолдолд хамаарахгүй.

218 дугаар зүйл. Ардын шүүх яллах дүгнэлт, бүртгэл, нотлох баримтыг хүлээн авч дараах зүйлсийг хянана. Үүнд:

- тухайн шүүхийн харьяалалд хамаарах эсэх;
- яллах дүгнэлтэд шүүгдэгчийн хувийн мэдээлэл, эрүүгийн хариуцлага хүлээж байсан, эсхүл одоо эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх, захиргааны шийтгэл, сануулах арга хэмжээ авсан эсэх, таслан сэргийлэх арга хэмжээ авсан байдал, баривчлах арга хэмжээ авсан хугацаа, төрөл, гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа, газар, арга хэрэгсэл, нийгмийн хор аюул болон ял шийтгэлд нөлөөлж болох бусад нөхцөл байдал, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол яллах дүгнэлтэд нэг бүрчлэн авч үзсэн эсэх;
- ял оногдуулахад нөлөөлөх нотлох баримт баталгаатай эсэх;
- шүүгдэгчийн хууль бус орлого, эд хөрөнгийг битүүмжилсэн, барьцаалсан, царцаасан арга хэмжээ авсан хугацаа дууссан эсэх;
- хохирогчийн овог, нэр, хаяг, холбоо барих арга хэрэгсэл;
- шүүгдэгчийн төлөөлөгч, өмгөөлөгчийн овог нэр, оршин суух хаяг, холбогдох арга хэрэгсэл тодорхой эсэх;
- иргэний нэхэмжлэгчтэй бол тухайн хүний овог, нэр, оршин суух хаяг, холбоо барих арга хэрэгсэл болон нотлох баримт нь холбоотой эсэх;
- хянах, мөрдөн шалгах ажиллагааны дүрэм зэрэг хуулийн бичиг баримт болон хавтаст хэрэг нь бүрэн эсэх;
- шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай холбоотой гаргасан санал, гэм буруугаа хүлээсэн бичиг зэрэг баримтууд гаргасан эсэх;
- эрүүгийн процессын хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээлгэхээргүй нөхцөл байдал байгаа эсэх.

240 дүгээр зүйл. Даргалагч шүүгч шүүх хуралдааныг нээсний дараа, эхлээд улсын яллагч яллах дүгнэлтээ уншиж сонсгоно; үүний дараа даргалагч шүүгч шүүгдэгчээс яллах дүгнэлтийн хүрээнд гэмт хэргийн бодит байдал болон ял оногдуулахад өөр саналтай эсэхийг асууна. Иргэний нэхэмжлэлтэй бол улсын яллагч яллах дүгнэлтийг уншиж сонсгосны дараа иргэний нэхэмжлэгч эсхүл бусад төлөөлөгч иргэний нэхэмжлэлийг уншиж сонсгоно.



241 дүгээр зүйл. Даргалагч шүүгчийн зөвшөөрлөөр шүүгдэгч болон хохирогч яллах дүгнэлтийн хүрээнд гэмт хэргийн бодит байдлын талаар тусдаа тайлбарлаж болно.

242 дугаар зүйл. Даргалагч шүүгчийн зөвшөөрлөөр улсын яллагч яллах дүгнэлтийн хүрээнд гэмт хэрийн бодит байдлын талаар шүүгдэгчээс мэдүүлэг авч болно.

365 дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх бол дараах байдлаар шүүх хуралдааныг явуулна. Үүнд:

- Улсын яллагч яллах дүгнэлтийн хураангуйг танилцуулна;
- Улсын яллагч, өмгөөлөгч, шүүгч шүүгдэгчээс хялбаршуулсан журмаар болон товч мэдүүлгийг авна;
- Яллах, өмгөөлөх талууд нотлох баримтад эсрэг саналтай байгаа бол зөвхөн нотлох баримтын нэр болон баталгаанд тайлбар хийнэ; хоёр тал эсрэг саналтай, эсхүл шүүх бүрэлдэхүүн нотлох баримтыг шалгах шаардлагатай гэж үзвэл нотлох баримтыг ил гаргах бөгөөд шалгана;
- Яллах, өмгөөлөх талууд оногдуулсан ялын хэмжээ болон нотлох баримтад маргаагүй бол шүүх оногдуулах ял болон хэмжээг шийдвэрлэнэ.
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн бол ял оногдуулахаас өмнө шүүгдэгчийн сүүлийн тайлбарыг сонсоно.

## II. ДҮГНЭЛТ

Харьцуулан судалгаанаас харвал хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэхэд хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл прокурор яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлдэг бөгөөд уг яллах дүгнэлтэд тусгах шаардлагатай мэдээллийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульдаа нарийвчлан заасан байна.

Яллах дүгнэлтийг бүтцийн хувьд авч үзвэл дараах ялгаатай байдал ажиглагдлаа. Зарим улсад яллах дүгнэлтийн бүтцийг эрүүгийн процессын хуульд нарийвчлан хуульчилжээ. Тухайлбал, Бүгд Найрамдах Армени улс, Бүгд Найрамдах Казахстан Улсыг улсад яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох, дүгнэх хэсгээс бүрдэн гэж тусгайлан хуульчилж, тухайн хэсэгт тусгах шаардлагатай мэдээллийг нарийвчлан тусгасан байна. Харин Бүгд Найрамдах Болгар Улсад яллах дүгнэлт нь хэргийн нөхцөл байдлын болон дүгнэлт гэсэн хэсгээс бүрдэнэ хэмээн хуульчилжээ.

Яллах дүгнэлтийг агуулгын хувьд авч үзвэл тухайн яллах дүгнэлтийг хаана, ямар албан тушаалтан үйлдэж байгаагаар эхэлдэг байна. Яллах дүгнэлтийн тогтоох хэсэгт яллагдагчийн талаарх мэдээлэл, гэмт хэрэг үйлдсэн газар, гэмт хэрэг үйлдсэн арга, ял хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлын талаар, бусад гэмт хэргээс ялгах болон эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэлтэй болохыг дэмжсэн бусад үйл баримт зэргийг тусгадаг нийтлэг шинж ажиглагдлаа. Мөн яллах дүгнэлтэд уг дүгнэлт гаргах үндэслэл болсон нотлох баримтын жагсаалт, холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалтууд, тэдгээрийг хэрэглэж гаргасан хууль зүйн дүгнэлт зэргийг тусгадаг байна.



Яллах дүгнэлтийн хавсралтад шүүх хуралдаанд оролцох шаардлагатай оролцогчдын жагсаалт, эд мөрийн баримт болон нотлох баримт, яллагдагч цагдан хоригдсон хугацааг зэргийг тусгадаг байна.

Дийлэнх улсад яллах дүгнэлтийг прокурор, мөрдөгч яллагдагчид танилцуулдаг бол ХБНГУ-ын хувьд яллах дүгнэлтийг шүүгч яллагдагчид танилцуулж байгаагаараа ялгаатай байна. Норвегийн Хаант Улсад гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүн яллагдагчаар татагдсанаас хойш 6 долоо хоногийн дотор яллах дүгнэлт үйлдэнэ хэмээн зааснаараа онцлог байна. Мөн тус улсад яллах дүгнэлт нь нийтэд нээлттэй эсэх талаар тусгадаг байна.

## НОМ ЗҮЙ

### 1. Эрх зүйн эх сурвалж:

1. Бүгд Найрамдах Польш Улсын Эрүүгийн процессын хууль. 1997 он.
2. Норвегийн Хаант Улсын Эрүүгийн процессын хууль. 1981 он.
3. Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүүгийн процессын хууль. 2014 он.
4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн процессын хууль. 1987 он.
5. Гүрж Улсын Эрүүгийн процессын хууль. 2009 он.
6. Бүгд Найрамдах Чех Улсын Эрүүгийн процессын хууль. 1961 он.
7. Бүгд Найрамдах Болгар Улсын Эрүүгийн процессын хууль. 2005 он.
8. Бүгд Найрамдах Армени Улсын Эрүүгийн процессын хууль. 2021 он.
9. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн процессын хууль. 1979 он.
10. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын прокурорын байгууллагын эрүүгийн хэрэгт заргалдах дүрэм. 2012 он.
11. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын прокурорын хууль. 2019 он.

### 2. Цахим эх сурвалж:

1. "ODIHR" Олон Улсын байгууллагын эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://legislationline.org/>
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэвтэрхий толь: <https://baike.baidu.com/>
3. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын прокурорын дээд байгууллагын цахим хуудас: <https://www.spp.gov.cn/>
4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ардын прокурорын газрын цахим хуудас: <https://www.12309.gov.cn/>